

ЗӨВШӨӨРСӨН:

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.....

С. ТӨГСДЭЛГЭР

БАТЛАВ:

ХАВДАР СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.....

Я. ЭРДЭНЭ-ОЧИР

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАВДАР СУДЛАЛ”

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА:ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ИНДЕКС:

ХУГАЦАА: 1 ЖИЛ

УЛААНБААТАР ХОТ

2023 ОНЫ 11 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Э.Амарсанаа, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч, АУ-ны доктор, дэд профессор, Хавдар судлалын “Зөвлөх” зэргийн эмч

В.Сувдмаа, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, Хавдар судлалын “Зөвлөх” зэргийн эмч

А. Эрдэнэжаргал, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, Хавдар судлалын “Тэргүүлэх” зэргийн эмч

Д. Жаргал, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, АУ-ны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн судлалын “Тэргүүлэх” зэргийн эмч

Ц. Пүрэвдулам, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, Хавдар судлалын “Ахлах” зэргийн эмч

Г. Лхагвадорж, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, АУ-ны магистр, Хавдар судлалын “Ахлах” зэргийн эмч

Г. Ням-Од, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, АУ-ны магистр

Х. Цэрэнчимэд, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч, АУ-ны магистр

Ж. Золжаргал, Хавдар судлалын үндэсний төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч.

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Ц. Бадамсүрэн, Хавдар судлалын үндэсний төвийн Сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга, АУ-ны доктор

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАВДАР СУДЛАЛ”

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

ДЭМБ-ын статистик мэдээллээр 2020 онд 19.2 сая гаруй хүн хорт хавдраар өвдөж, 9.9 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас баржээ. ДЭМБ-ын статистик мэдээлэлд зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлд хөх, түрүү булчирхай, уушги, бүдүүн шулуун гэдэс, умайн хүзүүний хорт хавдрууд байна.

Монгол Улсын хүн амын дунд 2022 онд 6885 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн ба зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлийн бүтцэд элэгний хорт хавдар 33.2%, ходоодны хорт хавдар 17.2%, уушги гуурсан хоолой хорт хавдар 7.6%, улаан хоолой 5.0%, умайн хүзүүний хорт хавдар 4.6% эзэлж байгаа ба нийт хорт хавдрын 67.6%-ийг дээрх хорт хавдрууд эзэлдэг.

Эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, хөх, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар зонхилох эхний 5 шалтгаан болж байна. Эмэгтэйчүүдийн байрлалын хувьд зонхилон тохиолдох 10 байрлалын хорт хавдрын дотор умайн хүзүүний хорт хавдар 5-р байрт, өндгөвчний хорт хавдар 10-р байрт ордог.

2022 онд бүртгэгдсэн зонхилох 10 байрлалын хавдрын 32.3% нь эрт үе шатандаа, 67.7% нь хожуу үе шатандаа оношлогджээ. 2022 оны хорт хавдрын тайлангаар 6885 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 3604 эрэгтэй, 3281 эмэгтэй байна. Үүнээс 58.4 хувь нь орон нутагт, 41.6 хувь нь Улаанбаатарт оношлогдсон байна.

Сүүлийн 5 жилийн статистик мэдээллээс харахад ХСҮТ-ийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг болон амбулаторт үйлчлүүлэгчидын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Жишээ нь 2019 онд эмэгтэйчүүдийн амбулаторт 10816 хүн, 2023 онд 17035 хүн үйлчлүүлж, 2019 онд хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч 2019 онд 646 эмэгтэйчүүд, 2023 онд 992 эмэгтэйчүүд хэвтэн мэс засалд орсон нь хорт хавраар өвчлөгсдийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна.

Эм бэлэг эрхтний хорт хавдрын эрт илрүүлэлт хангалтгүй байгаа нь эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмчийн хүрэлцээ муу, хавдрын тусламж үзүүлж байгаа эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын хавдрын талаарх мэдлэг чадвар, хандлага дутагдалтай байгаатай холбоотой гэж үздэг.

Иймд, хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ялангуяа эмэгтэйчүүдийн хавдрын

судлалын эмчилгээний чиглэлээр ажлын байранд сургах, дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, хувийн хэвшлийн эмнэлгийн Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарыг “Эмэгтэйчүүдийн хавдар судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтыг хэрэгжүүлж, 1 жил хүртэл хугацаатай байхаар хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Эрхэм зорилго:

Эх барих, эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч нарыг эмэгтэйчүүдийн хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр сургалтанд хамруулан мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх

Гурав. Алсын хараа

Эмэгтэйчүүдийн хавдар судлаач мэргэшсэн эмчийг бэлтгэснээр үйлчлүүлэгчдэд үйлчилгээг ойртуулж, хүлээгдэл, чирэгдлийг бууруулах, хавдрын оношилгоо болон эмчилгээний зөв арга, мэс заслын чадварт суралцах, эмчилгээний үр дүн дээшлэх, өвчний даамжрал, нас баралтыг бууруулах юм.

Дөрөв. “Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмч”-ийн цөм чадамж

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна.

1. Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмч
2. Мэргэжлийн байх
3. Суралцагч
4. Харилцагч
5. Хамтрагч
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч
7. Зохион байгуулагч, манлайлагч

Тав. Сургалтын зорилт

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно.

I. Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмч (Gynecological Oncologist)

- Эмэгтэйчүүдийн хавдрын амбулаторийн үзлэгт суралцах
- КТГ болон MRI шинжилгээнүүдийг уншиж суралцах
- Үтрээний дурангийн шинжилгээг үнэлж сурах

- Эд, эсийн шинжилгээний хариуг уншиж ойлгон дүгнэлтийг дүрсийн болон бусад шинжилгээтэй харьцуулан гаргаж эмчилгээний төлөвлөгөө гаргаж эмчлэх
- Эмэгтэйчүүдийн байрлалын хавдруудын үед хийх тохирсон мэс засал эмчилгээний аргыг эзэмших, суралцах
- Өвчтөний хувийн нууцыг хадгалах
- Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал эмчилгээний дараах өвчтөний хяналтыг хийх
- Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал болон туяа, хими эмчилгээний дарах хяналтын үзлэг, эмчилгээний аргад суралцаж дүгнэлт өгдөг байх
- Эмчилгээний үр дүнг тооцож, судалгаа, дүгнэлт гаргах
- Мэс засал эмчилгээний явцад болон дараа нийгмийн харилцаанд хэвийн оролцох, гоо зүйн талаас гарсан өөрчлөлтийн улмаас өвчтөнд үүсэх эмнэл зүй болоод сэтгэл зүйн гэмтлийн онцлогийг ойлгон мэдэрч өвчтөн болон ар гэр, садан төрлийнхөнтэй нь хүндэтгэлтэй хялбар үгээр харилцах, зөвлөх, энэ талаар хяналтын бусад эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, тэдгээрт зөвлөмж өгөх
- Хорт хавдрын эцсийн шатанд орсон, хөнгөвчлөхийн өвчтөн болон түүний ар гэрийн амьдралын чанарт гарах өөрчлөлтийг ойлгон, тэдэнд нөхцөл байдлыг ойлгуулах, хэцүү байдлаас урьдчилан сэргийлэхэд туслах, дэмжих, хөнгөвчлөх тусламжийг бусад эмч нартай хамтран үзүүлэх
- Эмнэлгийн бусад тасгийн эмч нар болон бусад эмнэлгийн эмч нартай мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцан хамтран ажиллах
- Эмчийн ёс зүй болон хүний ёс зүйг эрхэмлэдэг, зөв хандлагатай, багаар ажиллах

II. Мэргэжлийн байх (Professionalism):

- Орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах

III. Суралцагч (Learner):

- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд хамрагдах
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах

IV. Харилцагч (Communicator):

- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах
- Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах
- Шаардлагатай тохиолдолд өвчтний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх

V. Хамтрагч (Collaborator):

- Тухайн орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах

VI. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate):

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх

VII. Зохион байгуулагч, манлайлагч (Leader):

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

Зургаа. Сургалтын арга зүй

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалтад эмэгтэйчүүдийн амбулаторийн үзлэг болон мэс засал эмчилгээг төгс, төгс бус болон хөнгөвчлөх зорилгоор хийгдэж буй мэс засал эмчилгээний тусламжийг бүлэглэсэн гурван тойролтоор эзэмшинэ.
- Сургалтын нийт хугацаа 1 жил байна.
- Сургалтыг жил бүрийн 10 сарын 01-ны өдрөөс эхлэнэ.
- Нэг тойролтын хугацаа агуулга, сургалт эрхлэх хүчин чадлаас хамааран 12-15 долоо хоног байна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон долоо хоногийн үйл ажиллагаа хавсралтад буй эмнэл зүйн багшийн ажлын хуваарьтай уялдсан тойролтын хуваарийн дагуу явагдана.
- Хавдар судлалын үндэсний төвийн эмэгтэйчүүдийн амбултор болон тасагт уг сургалтыг эрхлэн явуулна.

6.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл

Тайлбар: Тойролт бүрт суралцагч дараах эмнэл зүйн чадварыг эзэмшиж дадлагажина. Тойролт бүрийн хуваарьт агуулга буюу судлах өвчин эмгэг, хийж

сурах гардан үйлдлийг жагсаасан бөгөөд эмэгтэйчүүдийн байрлалын хавдрын оношилгоо болон эмчилгээний аргад суралцаж, авах арга хэмжээ, эмчилгээний үр дүнг тооцох дүрс оношлогооны мэдлэг, онцлог асаргаа сувилгааны болон бусад чадварыг тухайн тойролт тус бүрийн агуулгаат багтаан үзэж эзэмшинэ.

- Өвчтөний биеийн ерөнхий эрүүл мэндийн байдал, одоогийн өвчний түүхийг нарийвчлан авч амьдралын, нийгмийн амьдралын болон удамшлын түүхээс уг өвчний шалтгаан нөлөөллийг олж тогтоон өөрт нь болон асран хамгаалагчид нь зөвлөгөө өгөх, мэс засал, хими, туяа эмчилгээний түүх, асран хамгаалагчийн дэмжлэг, асаргааны боломж байдал, орон нутгийн эмчийн талаарх мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх
- Эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаторийн болон хэвтэн эмчлүүлж буй өвчтөнийг үзэж, оношилж эмчлэх явцдаа дараах шинж тэмдгүүд, өвчнийг таньдаг болж гардан үйлдлийг бие даан хийж туршлага хуримтлуулна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАВДАР СУДЛААЧ ЭМЧИЙН СУРГАЛТЫН ТОЙРОЛТ

Ажлын байранд өвчтөнтэй харилцахдаа дадлагжигч эмч нар дараах чадварыг эзэмшсэн байх шаардлагатай:

- Хавдрын эмчилгээний чиглэлээр өвчтөнд зөвлөгөө өгөх чадвартай болсон байх
- Хавдартай өвчтөнүүдэд тусламж үзүүлэхдээ ёс зүйг сайтар баримталж харилцах
- Олон өвчтөнтэй харилцаж асуудлыг шийдэх мэргэжлийн чадварыг эзэмшсэн байх
- Өвчтөн болон түүний ар гэрийхэнтэй нинжин сэтгэлээр хандах харилцах
- Шийдвэр гаргахдаа мэргэжлийн ёс зүй, хэм хэмжээг баримтлах

Өвчтөн бүрт дараах үнэлгээг нарийвчлан хийх:

- Эмчилгээнд орох, зөвлөгөө авах, оношилгоо хийлгэх зэргээр ямар зорилгоор ирсэнийг сайтар тодруулах /Урьд нь эмчилгээ хийлгэж байсан эсэх, паспортын хэсэг өвчтөний овог нэр, нас хүйс, онош зэргийг шалгах/
- Өвчтөнд өвчний онош, оношилгоо, эмчилгээний арга барилыг нарийвчлан сайтар ойлгуулах
- Эмчилгээтэй холбоотой мэс заслын эрсдэл, хүндрэлийг тайлбарлах, үнэлэх
- Өвчтөний ар гэрт эмчилгээний явцын асаргаа эмч-өвчтөн-ар гэрийн холбоо харилцааны ач холбогдлыг танилцуулах

Хяналтын тойрон үзлэг:

- Хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багш (бусад эмч)-д танилцуулах зорилготой үзлэг.
- Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, өвчтөнтэй уулзаж, асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багш (бусад эмч)-д танилцуулахад бэлдэнэ.
- Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багш (бусад эмч)-тай хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг:

- Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.
- 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Хэлэлцүүлгийн явцад эмнэлзүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

Ажлын байрны сургалт (On the job training - OJT)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Хугацаа	Сургалт явагдах газар	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	3	8 цаг, долоо хоногт 5 удаа	Амбулатори	Эмнэлзүйн багш, сувилагч
Тасагт өвчтөн үзэх	2	Ажлын өдөр бүр	Тасаг	Эмнэлзүйн багш, бусад эмч, сувилагч

Танхимын сургалт (Off the job training - Off JT)

Дараах клиник онкологийн суурь мэдлэгийг уншиж судлах:

- Эмэгтэйчүүдийн байрлалын хавдар
- КТГ болон MRI шинжилгээний талаар
- Туяа болон Хими эмчилгээний ойлголт
- Гардан үйлдлийн стандартыг мэдэх

Уншиж судлах ном:

- Умайн салстын өмөн ном. УБ хот. 2013 он.
- Өндгөвчийн өмөн ном. УБ хот. 2018 он.
- Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар ном. УБ хот. 2021 он.
- Эмэгтэйчүүдийн хавдар судлал ном. УБ хот. 2021 он.

Ажлын бус цагаар бие даан унших сэдвүүд:

- Хавдрын эрсдэлт хүчин зүйл, удамшлийн нөхцөл, үсэрхийлэл, тавилан
- Өвчтөний хяналтын хугацаанд оношилгооны нарийвчилсан шинжилгээг зөвлөх/зөвхөн хавдрын маркер, цусны шинжилгээгээр хязгаалахгүйгээр багажын шинжилгээ, дуран гм /

Хавдрын TNM үе шатыг олон төрлийн хавдрын үед ашиглаж сурах өөр өөр эмчилгээний арга замууд тэдгээрийн үр дүн, үйлдлийн механизм, заалтыг мэдсэн байх

- Хими эмчилгээ
- Гормон эмчилгээ
- Биологийн эмчилгээ
- Ерөнхий мэс засал эмчилгээний үндсэн ухагдахуун
- Хавдрын урьдчилан сэргийлэлт ба эрт илрүүлэг
- Дархлаа дарангуйлагдсан өвчтөнүүд, жирэмсэн эмэгтэй, өндөр настай өвчтөнүүд, өсвөр насныхан гэх мэт тусгай бүлгийн өвчтөнүүдэд менежмент хийх
- Эмчилгээний явцад илэрсэн хурц, урт хугацааны болон хожуу илрэх мэс заслын хүндрэлүүд
- Хавдрыг даван туулсан өвчтөнүүдийн бие махбодиос гадна сэтгэл зүй, нийгэм, амьдралын хэв маяг, сексийн амьдрал, үргүйдэл зэрэг асуудлыг уншиж судлах

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
<i>Бие даалт</i>	1	Чөлөөт цагаар	Сургалтын өрөө, гэртээ, номын сан	Ном, интернэт	Өөрөө, хамтран суралцагч
<i>Лекц</i>	5 хүртэл	Сургалтын эхний 3 сард багтаан 9 сэдвээр лекц орно.	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар	Эмнэлзүйн сургагч багш, суралцагч эмч нар
<i>Семинар</i>	1-5	7 хоногт 1-2 удаа 1 цаг 30 мин	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар	Эмнэлзүйн сургагч багш, суралцагч эмч нар
<i>Журнал клуб</i>	1-5	Сард 1 удаа	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш, суралцагч эмч нар

Тойролтын хуваариуд

1. Умайн их бие, умайн хүзүүний хавдрын тойролтын хуваарь: C54, C53

Хугацаа: 24 долоо хоног

<i>Гараг</i>	<i>08:00 – 08:30</i>	<i>08:30 – 09:00</i>	<i>09:00 – 13:00</i>	<i>13:30 – 15:00</i>	<i>15:00 – 16:30</i>
<i>Даваа</i>	Ганцаарчилсан үзлэг	Тасгийн тойрон үзлэг	Амбулторт өвчтөн үзэх, мэс засал эмчилгээнд оролцох, өвчний түүх хөтлөх		Лекц, семинар
<i>Мягмар</i>	Ганцаарчилсан үзлэг	Эмч нарын яриа	Амбулторт өвчтөн үзэх, мэс засал эмчилгээнд оролцох, өвчний түүх хөтлөх		
<i>Лхагва</i>	Ганцаарчилсан үзлэг	Амбулаторт үзлэг хийх			
<i>Пүрэв</i>	Ганцаарчилсан үзлэг	Тасгийн тойрон үзлэг	Амбулторт өвчтөн үзэх, мэс засал эмчилгээнд оролцох, өвчний түүх хөтлөх		Лекц, Семинар
<i>Баасан</i>	Ганцаарчилсан үзлэг	Тасгийн тойрон үзлэг	Эмчилгээний хяналт		Журнал клуб

Тойролтын агуулга:

- Умайн их бие, умайн хүзүүний хавдрын ерөнхий ойлголт, эс, эдийн шинжилгээ авах
- Умайн их бие хавдрын эпидемиологи. Умайн их биеийн хавдрын шалтгаант хүчин зүйл, патоморфологийн ангилал

- Умайн их бие, умайн хүзүүний хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Умайн их бие, умайн хүзүүний хавдрын мэс засал эмчилгээний ерөнхий зарчим, эмчилгээний төлөвлөгөө гаргах
- Умайн их бие, умайн хүзүүний хавдрын мэс засал эмчилгээний заалт, эсрэг заалт, хүндрэлийг тодорхойлох, тэдгээрийн эмчилгээ
- Умайн их бие, умайн хүзүүний хавдар тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
- Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний дараах хяналт
- Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
- Хавсралт-1 ийн үйлдлийг гардан үйлдлийг судлах, эзэмших

2. Өндгөвчний хавдрын тойролтын хуваарь: C56

Хугацаа: 20 долоо хоног

	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00	15:00 – 16:30
--	------------------	------------------	------------------	------------------	------------------

Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Амбулторт өвчтөн үзэх, мэс засал эмчилгээнд оролцох, түүх нээх,хаах	Лекц, семинар
Мягмар	Ганцаарчилсан үзлэг	Эмч нарын яриа	Амбулторт өвчтөн үзэх, мэс засал эмчилгээнд оролцох, түүх нээх,хаах	
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Амбулаторийн үзлэг		
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Амбулторт өвчтөн үзэх, мэс засал эмчилгээнд оролцох, түүх нээх,хаах	Лекц Семинар
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Эмчилгээний хяналт	Журнал клуб

Тойролтын агуулга:

- Өндгөвчний хавдрын ерөнхий ойлголт.
- Өндгөвчний хавдрын эпидемиологи. Умайн их биеийн хавдрын шалтгаант хүчин зүйл, патоморфологийн ангилал
- Өндгөвчний хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Өндгөвчний хавдрын мэс засал эмчилгээний ерөнхий зарчим,
- Өндгөвчний хавдрын мэс засал эмчилгээний төлөвлөгөө гаргах
- Өндгөвчний хавдрын хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох,
- Өндгөвчний хавдар тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
- Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний дараах хяналт
- Адьювант эмчилгээний онцлог үр дүн
- Неадьювант эмчилгээний онцлог үр дүн
- Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
- Хавсралт-1 ийн үйлдлийг гардан үйлдлийг судлах, эзэмших

3. Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын тойролтын хуваарь: C51, C-58

Хугацаа: Ажлын 8 долоо хоног

Гараг	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00	15:00 – 16:30
Даваа	Бие даан	Тасгийн	Амбулаторт өвчтөн үзэх, мэс		Лекц,

	Үзлэг хийх	тойрон үзлэг	засалд оролцох, өвчний түүх хөтлөх	семинар
<i>Мягмар</i>	Бие даан Үзлэг хийх	Эмч нарын яриа	Амбулторт өвчтөн үзэх, мэс засалд оролцох, өвчний түүх хөтлөх	
<i>Лхагва</i>	Бие даан Үзлэг хийх	Амбулаторт үзлэг хийх		
<i>Пүрэв</i>	Бие даан Үзлэг хийх	Тасгийн тойрон үзлэг	Амбулторт өвчтөн үзэх, мэс засалд оролцох, өвчний түүх хөтлөх	Лекц, Семинар
<i>Баасан</i>	Бие даан Үзлэг хийх	Тасгийн тойрон үзлэг	Эмчилгээний хяналт	Журнал клуб

Тойролтын агуулга:

- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын ерөнхий ойлголт.
- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын эпидемиологи. Умайн их биеийн хавдрын шалтгаант хүчин зүйл, патоморфологийн ангилал
- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын мэс засал эмчилгээний ерөнхий зарчим,
- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын мэс засал эмчилгээний төлөвлөгөө гаргах
- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох,
- Гадна бэлэг эрхтэний хавдар, ихэсийн хавдрын тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
- Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний дараах хяналт
- Адьювант эмчилгээний онцлог үр дүн
- Неадьювант эмчилгээний онцлог үр дүн
- Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
- Хавсралт-1 ийн үйлдлийг гардан үйлдлийг судлах, эзэмших

Хавсралт. 1

Эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмч нарт унших лекц

№	Лекцийн сэдэв	Хугацаа	Унших багш
---	---------------	---------	------------

1.	1. “Өндгөвчийн өмөнгийн оношилгоо, эмчилгээ”	Сургалтын 3 дах сард багтаан уншина	ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн эрхлэгч, Э.Амарсанаа Эмнэлзүйн сургагч багш
	2. “Эмэгтэйчүүдийн эрхтэний хортой хавдрын үед хийгдэх хавдрын биомаркеруудын хэрэглээ”	Сургалтын 3 дах сард багтаан уншина	ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн Эрхлэгч, АУ-ны доктор, дэд профессор Э.Амарсанаа Эмнэлзүйн сургагч багш
	3. “Гадна бэлэг эрхтэн болон үтрээний өмөнгийн оношилгоо, эмчилгээ”		
2.	4. “Трофобластын өвчний оношлогоо, эмчилгээ”	Сургалтын 3 дах сард багтаан уншина	ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн эрхлэгч, Э.Амарсанаа Эмнэлзүйн сургагч багш
	5. “Умайн салстын өмөнгийн оношилгоо, эмчилгээ”		
3.	6. “Үтрээний дурангийн оношилгоо(Кольпоскопи)”	Сургалтын 3 дах сард багтаан уншина	ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн эрхлэгч Э.Амарсанаа Эмнэлзүйн сургагч багш
	7. Умайн хүзүүний урьдал эмгэгийн оношилгоо, эмчилгээ	Сургалтын 3 дах сард багтаан уншина	ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн эрхлэгч, Э.Амарсанаа Эмнэлзүйн сургагч багш
4.	8. “Умайн хүзүүний өмөнгийн үед хийгдэх төгс мэс заслын эмчилгээний төрлүүд”	Сургалтын 3 дах сард багтаан уншина	ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн эрхлэгч, Э.Амарсанаа Эмнэлзүйн сургагч багш
	9. “Умай авах мэс заслын төрлүүд, тэгдгээрийн онцлогууд”		

Хавдар Судлалын Үндэсний Төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг хэрэглэгдэж буй үйлдлийн стандарт болон оношлогоо, эмчилгээний удирдамжууд

Хийгдэж буй мэс заслын багц нэрс	Хагалгааны нэрс	ICD-10	Мөрдөгдөж буй стандарт
Тунгалагийн	Хэвлийн гол ба бага	(40.52-	MNS 5855-2 : 2011

тогтолцоонд хийх мэс засал	аарцгийн тунгалагийн булчирхайг түүх мэс засал	40.59)	
Гэдсэнд зүслэг хийх, тайрах, залгалт хийх	Нарийн болон бүдүүн гэдэс тайрах, залгах мэс засал	(45.0-45.9)	MNS 5859 : 2008
Гэдсэнд хийгдэх бусад мэс заслууд	Нарийн гэдэс болон бүдүүн гэдэс гадагш гаргах	(46.0-46.9)	MNS 5859 : 2008
Мухар олгойг мэс заслууд	Мухар олгой авах мэс засал	(47)	MNS 5859 : 2008
Хэвлийн бусад хэсгийн засал	Хэлийн хананд зүслэг хийх, давтан зүслэг хийх, Хэвлийг нээж шалгах, Хэвлийн хөндийг оношлогооны зорилгоор дурандах	(54.0-54.7, 54.9)	MNS 4621 : 2008
Өндгөвчинд хийгдэх мэс заслууд	Нээлттэй болон дурангаар аль нэг талын болон хоёр талын өндгөвч, үрийн хоолойн хамт авах Өндгөвч хэсэгчлэн тайрах	(65.0-65.9)	MNS 5855-1 : 2010
Умайн гуурсан хоолойд хийгдэх мэс заслууд	Нээлттэй болон дурангаар умайн гуурсан хоолойг тайрах	(66.0-66.9)	MNS 5855-4 : 2010
Умайн хүзүүнд хийгдэх бусад ба тайралт	Умайн хүзүүн сувгийг тэлэх, Умайн хүзүүг өөлж, тайрч авах	(67.0-67.6)	MNS 5855-2 : 2011
Умайд хийгдэх бусад зүслэг ба тайралт	Нээлттэй болон дурангаар Умайг үтрээний дээгүүр болон умайн хүзүүн дээгүүр авах, 2 талын дайвар болон дайваргүй авах	(68.0-68.9)	MNS 5855-4 : 2010
Умай түүнийг бэхлэх холбоосон эдэд хийгдэх хагалгаанууд	Умайн хөндийг хусч цэвэрлэх	(69.0-69.9)	MNS 5855-4 : 2010
Үтрээ ба дугласын хөндийд /арын хүнхрээнд / хийгдэх хагалгаанууд	Үтрээний арын хүнхрээнээс эдийн шинжилгээ авах	(70.0-70.9)	MNS 4621 : 2008
Бэлгийн уруул, хязанд хийгдэх хагалгаанууд	Бэлгийн уруулаас эдийн шинжилгээ авах, Бартолин булчирхай авах	(71.0-71.9)	MNS 5855-5 : 2008
Арьс, арьсан доор эдийг зүсэх	Арьс, арьсан дор зүслэг хийх	(86.9)	MNS 4621 : 2008

ҮЙЛДЛИЙН СТАНДАРТ

№	Үйлдлийн стандарт	Мөрдөгдөж буй стандарт
1	Үтрээний үзлэг	MNS4621:2008
2	Үтрээн толины шинжилгээ	MNS4621:2008
3	Умайн хөндийг багажаар цэвэрлэх үйлдэл	MNS4621:2008

4	Умайн хөндийн ерөндөг (мушгиа) тавих	MNS4621:2008
5	Умайн хүзүүний шархлааг цахилгаан гүйдлээр эмчлэх	MNS4621:2008
6	Үтрээний арын хүнхрээгээр хатгалт хийх	MNS4621:2008
7	Үтрээ, умайн хүзүүг дурандах(кольпоскопи)	MNS4621:2008
8	Умайн хөндийг дурандах (гистероскопи) шинжилгээ	MNS4621:2008
9	Умайн хүзүүнээс эд авч шинжлэх	MNS4621:2008
10	умайн хөндийгөөс соруураар соруулах үйлдэл	MNS4621:2008
11	Оношлогооны дуран мэс заслын аргачлал	MNS4621:2008

ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

№	Үйлдлийн стандарт	Мөрдөгдөж буй стандарт
1	Өндгөвчийн хорт хавдрын оношлогоо, эмчилгээний удирдамж	MNS5855-1:2010
2	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэлт, оношлогоо, эмчилгээ ба хяналт удирдамж	MNS5855-2:2011
3	Умайн их биеийн хорт хавдрын оношлогоо, эмчилгээний удирдамж	MNS5855-4:2010
4	Үтрээний хавтгай хучуур ба булчирхайлаг эдээс гаралтай хорт хавдрын оношлогоо, эмчилгээний удирдамж	MNS5855-5:2008
5	Хориокарцином хавдрын оношлогоо, эмчилгээний удирдамж	MNS5855-6:2008
6	Гадна бэлэг эрхтний хорт хавдрын оношлогоо, эмчилгээний удирдамж	MNS5855-3:2008

Дадлага, семинар

Дадлага, семинар				
	Мэс заслын явц (хэвлийг нээх, хаах)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Умай авах мэс заслын төрлүүдэд суралцах (ТАН, TLH, LAVH, RSH)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Өндгөвчинд хийгдэх мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	(хоёр талын өндгөвч үрийн хоолой авах, нэг талын өндгөвч авах, өндгөвч тайрах)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин

Дадлага

	Дурангийн мэс заслын гардан үйлдлүүд (Верешийн зүү ашиглан эхний трокар хатгах техник, дурангаар 2,3-р трокаруудыг хатгах техник, дурангаар бага аарцгийн эрхтэнүүд шалгах)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
Дадлага, семинар				
	Умайн хүзүүний өөрчлөлттэй хэсгээс эдийн шинжилгээ авах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Гадна бэлэг эрхтний өөрчлөлтөөс эд эсийн шинжилгээ авах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Умайн хөндий, сувгаас эд эсийн шинжилгээ авах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Арын хүнхрээгээр хатгалт хийх	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Хэвлий хөндийд хатгалт хийх асцитын шингэн авах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
Дадлага, семинар				
	Умай авах мэс заслын арга барилаас суралцах (TАН, TLH, LAVH, RSH)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Хэвлийн нээлттэй аргаар умайг авах мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Үтрээгээр умайг авах мэс засал	Эмнэлзүйн	Дадлага	90 мин

Дадлага

		сургагч багш		
	Хэвлийн дурангаар умайг авах мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Хэвлийн дурангийн тусламжтай үтрээгээр умайг авах мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Нэг зүслэгт дурангийн мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
Дадлага, семинар				
	Өвчтөнг мэс засалд бэлдэх, шинжилгээ бүрдүүлэх,	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	
	Мэс заслын өмнөх өвчтнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдэлийг үнэлэх	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	
	Бага аарцгийн тодосгогчтой КТГ болон MRI шинжилгээг үнэлэх	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	
Дадлага, семинар				
	Умайн хоргүй хавдар авах мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Оношлогооны дурангийн мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин

	Өндгөвчийн хавдар авах мэс засал (нээлттэй болон дурангаар)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлаага	90 мин
	Умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлөх мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлаага	90 мин
	Умайн хүзүүг хутгаар тайрч авах мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлаага	90 мин

Дадлага, семинар				
	Мэс заслын явцтай танилцах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Умай авах мэс заслын төрлүүдэд суралцах (ТАН, ТЛН, LAVH, RSH)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Умай авах мэс засалын төрлүүдэд суралцах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Өндгөвчинд хийгдэх мэс засал	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	(хоёр талын өндгөвч үрийн хоолой авах, нэг талын өндгөвч авах, өндгөвч тайрах)	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин
	Дурангийн мэс заслын гардан үйлдлүүд (Верешийн зүү ашиглан эхний трокар хатгах техник, дурангаар 2,3-р трокаруудыг хатгах	Эмнэлзүйн сургагч багш	Дадлага	90 мин

Дадлаага

	техник, дурангаар бага аарцгийн эрхтэнүүд шалгах)			
Дадлага, семинар				
	Умайн хүзүүний өөрчлөлттэй хэсгээс эдийн шинжилгээ авах	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Гадна бэлэг эрхтний өөрчлөлтөөс эд эсийн шинжилгээ авах	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Умайн хөндий, сувгаас эд эсийн шинжилгээ авах	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Арын хүнхрээгээр хатгалт хийх	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Хэвлий хөндийд хатгалт хийх асцитын шингэн авах	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
Дадлага, семинар				
	Умай авах мэс заслын арга барилаас суралцах	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Хэвлийн нээлттэй аргаар умайг авах мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Үтрээгээр умайг авах мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин

Дадлаг
а

	Хэвлийн дурангаар умайг авах мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Хэвлийн дурангийн тусламжтай үтрээгээр умайг авах мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Нэг зүслэгт дурангийн мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин

Дадлага, семинар

	Умайн хоргүй хавдар авах мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Оношлогооны дурангийн мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Өндгөвчийн хавдар авах мэс засал (нээлттэй болон дурангаар)	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлөх мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин
	Умайн хүзүүг хутгаар тайрч авах мэс засал	Эмнэлз үйн сургагч багш	Дад лага	90 мин

Сургалтын үнэлгээ, эргэн зөвлөгөө

7.1. Суралцагч эмч ба хариуцагч (mentor)

Суралцагч эмч бүрт сургалтын нэг жилийн хугацаанд хариуцагч эмч (mentor)-ийг тасгийн эрхлэгч хуваарилж өгнө. Хариуцагч эмч (mentor) нь хариуцсан суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, хэрхэн ахин дэвшиж байгаа болон юунд анхаарах, хэрхэн сайжрахыг эргэн зөвлөнө. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагч эмчтэй уулзах ба цаашид 2-3 сар буюу тойролт бүрийн дараа уулзаж ярилцан үнэлгээтэй танилцаж эргэн зөвлөгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрийг эмнэл зүйн сургагч багш удирдана. Тойролт удирдах эмнэлзүйн сургагч багшийг тасгийн эрхлэгч суралцагч бүрт оноож өгнө.

- Суралцагч нь тойролт бүрийн эхэнд сургагч багштай уулзан тойролтын хуваарьтай танилцан тухайн тойролтод сурч эзэмшихээр зорьсон зорилтоо ярилцана.
- Тойролтын явцад зорилтондоо хүрэхэд дутагдаж байгаа болон нөхөх хэрэгцээтэй байгаа зүйлсээ ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

VII.3. Үнэлгээний арга, төлөвлөгөө

Үнэлгээг дараах төлөвлөгөөний дагуу үнэлгээний аргаас хамааран эмнэл зүйн сургагч багш, тасгийн бусад эмч, сувилагч, өвчтөн, сургалтын албаны ажилтан, шалгалтын комисс хуваарийн дагуу хийнэ. Явцын үнэлгээний дүнг суралцагч эмчээс гадна сургалтын алба хадгалах ба эмнэл зүйн багш, сургалтын албанаас суралцагчид үнэлгээнээс хамааран цаашид сургалтыг амжилттай дүүргэхэд шаардлагатай зохих заавар зөвлөмжийг өгнө.

7.3.1. Үнэлгээний төлөвлөгөө

Зорилтууд	Үнэлгээний хэлбэр	Хамрах чиглэл	Арга, хэрэгсэл	Үнэлэгч/хэмжигч	Цаг хугацаа
1-6, 8	Явцын	Мэдлэг, чадвар	Дадлага: Mini-CEX, DOPS	Тасгийн эмч, эмнэл зүйн багш	Тойролт бүрт 5-8 удаа
7, 12, 13	Явцын	Мэдлэг, хандлага, багаар ажиллах чадвар	Дадлага: 360 хэмийн үнэлгээ, Ажиглалтын тэмдэглэл	Тасгийн эмч, эмнэл зүйн багш, ахлах сувилагч, өвчтөн	Тойролт бүрт 1-2
9-10,13	Явцын	Хандлага,	Дадлага: 360	Тасгийн эмч,	Тойролт

		чадвар	хэмийн үнэлгээ, Ажиглалтын тэмдэглэл	эмнэл зүйн багш, өвчтөн	бүрт 1-2
11, 12	Явцын, нэгдсэн	Хандлага, чадвар	Ажиглалт, аман: Ажиглалтын тэмдэглэл, бүтээлийн сангийн үнэлгээ, тайлан	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Сургалтын хугацаанд байнга ба төгсөлтийн өмнө
1-13	Нэгдсэн	Мэдлэг, хандлага, чадвар	Дадлага, онолын мэдлэг, Тайлан, төгсөлтийн шалгалт: тест, гардан үйлдэл	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Төгсөлтийн нэгдсэн шалгалт
1-13	Нэгдсэн	Мэдлэг, хандлага, чадвар	Төгсөлтийн тестийн шалгалт, гардан шалгалт	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Төгсөлтийн нэгдсэн шалгалт

7.3.2. Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace based assessment)

а) 360 хэмийн үнэлгээ (360 degree assessment)

Суралцагч эмчийн мэргэжилтний хувьд хэр "мэргэжлийн" (professional) байгааг үнэлэх зорилгоор сургалтын явцад тойролт бүрт үнэлнэ. Тойролт удирдсан багш нар болон сувилахуйн мэргэжилтэн, тасаг нэгжийн хамт ажилласан эмч, өвчтөн, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг нийт таван хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүмүүсийг сургалтын албанаас томилох ба үнэлгээний дүнг суралцагч эмч болон эмнэл зүйн сургагч багшид танилцуулж үнэлгээнд үндэслэсэн цаашдын зөвлөгөөг эмнэл зүйн сургагч багш суралцагчид өгнө.

б) Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-CEX: Mini – Clinical Evaluation Exercise)

Өвчтөний шинжилгээнүүд болон эмнэл зүйг үндэслэн хэрхэн эмчилгээ төлөвлөх, эмчилгээний явцад болон дараах мэс заслын хүндрэл, хяналтын шинжилгээ, эмнэл зүйд илрүүлэн таньж тойролт бүрт арваас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Эмнэл зүйн үнэлгээ хийх эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч өөрөө сонгон үнэлүүлэх ба сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид юун дээр анхаарах, хэрхэн сайжрах зөвлөгөөг заавал өгнө.

в) Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills)

Зайлшгүй сурах гардан үйлдлийн 80-аас багагүй хувийг бие даан хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч өөрөө сонгон үнэлүүлэх ба сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр

дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид юун дээр анхаарах, хэрхэн сайжрах зөвлөгөөг заавал өгнө.

г) Бүтээлийн сангийн (Portfolio) үнэлгээ

Суралцагч эмч сургалтын хугацааны лекц, бие даалтаар хийсэн болон семинар, журнал клуб, сургалтын тойрон үзлэг зэрэг сурах хугацаандаа хийсэн сурсан, бүтээсэн зүйлсийн тайлан материалыг цуглуулан “бүтээлийн сан” болгон хадгална. Үүнд хариуцагч болон эмнэл зүйн багштай зөвлөлдсөн, зөвлөгөө авсан тэмдэглэл, эмч нарын зөвлөгөөнөөс сурч ойлгосон мэдлэгийн тэмдэглэл зэрэг мөн багтана.

7.4. Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг цаг тухайд нь авахуулж сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багшид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгалж, тойролт бүрийн төгсгөлд сургалтын албанд Mini-CEX ба DOPS үнэлгээний дүнг хүлээлгэж өгнө.
- Эмнэл зүйн багш ажиглан “ажиглалтын тэмдэглэл” хөтлөнө. Энэ тэмдэглэлд семинарийн идэвх оролцооны үнэлгээг болон явцын бусад дадлага ажлын үед ажиглагдсан, суралцагчийн цаашдын хөгжил дэвшилд хэрэг болохуйц гэж үзсэн санал, үнэлгээг тэмдэглэн оруулж болно.
- Сургалтын алба үнэлгээний дүнг суралцагч болон хариуцагч, эмнэл зүйн сургагч багшид сургалтын нийт хугацааны дунд хагаст танилцуулах ба цаашид юунд анхаарах, төгсөх хүртэл юуг хийсэн байх талаар зөвлөгөө өгнө.

7.5. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Сургалтын хугацааны төгсгөлд “ажиглалтын тэмдэглэлүүд”-ийг эмнэл зүйн багшаас сургалтын алба авч нэгтгэн суралцагчийн хөгжил дэвшлийг үнэлэхэд мөн төгсөлтийн шалгалтын үнэлгээнд харгалзана.
- Тойролт бүрт хийгдсэн Mini CEX ба DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын алба, хариуцагч ба эмнэл зүйн багшийн хамт гаргана. Үүнд тойролт бүрт хийгдсэн Mini CEX ба DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэх шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
 - ❖ Зайлшгүй сургалтанд оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн

20%-иас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

- ❖ Зайлшгүй таньж мэдэх өвчний оношилгоо, эмчилгээ, ялгах шинж тэмдгүүдийг 1 жилийн турш оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний болон оролцсон хагалгааны тохиолдлын тоо нь тойролт бүрийн хуваарьт тусгагдсаны дагуу байна.
- ❖ Тойролтын дараа ба хагас жилээр эсвэл сургалтын хугацааны төгсгөлд суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагч, эмнэл зүйн сургагч багш тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.
- Сургалтын алба сургалтын хариуцагч болон сургалт явагдсан тасгийн эмнэл зүйн сургагч багш нараас оролцуулан шалгалтын комиссыг бүрдүүлж төгсөлтийн шалгалтыг зохион байгуулна.

Найм. Хэрэгжүүлэлт

(Хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх, хянах)

8.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт ба сургалтын алба

- Суралцагчийн тоо, тойролтын хуваарийг эмнэл зүйн багшийн болон сургалт явуулах байгууллага, тасгийн үйл ажиллагаатай уялдуулан сургалтын алба сургалтын хариуцагч (mentor) эмчтэй хамтран зөвшилцөж хийнэ.
- Сургалтын эхэнд тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, эмнэлгийн үйл ажиллагаа, дотоод журам, эмчилгээ оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгаалалын талаарх гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг сургалтын албанаас зохион байгуулна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын алба, сургалт явуулах байгууллага, сургалт хариуцагч, тасгийн сургагч багш нартай хэлэлцэн нэмэлт өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Суралцах нийт хугацааны туршид хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн хөтөлбөрийн дүүргэлтийг сургалтын алба хянаж ажиллана.

8.3 Сургалтын танилцуулга

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, төвийн үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хяналтын талаар суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Хавсралт 2

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш Сувилагч Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр бусдаас сонссон мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор ($\leq 19\%$)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд ($\geq 80\%$)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	NA <input type="checkbox"/>	1 <input type="checkbox"/>	2 <input type="checkbox"/>	3 <input type="checkbox"/>	4 <input type="checkbox"/>
Эмнэлгийн бичиг баримтыг гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.					
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.					
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.					
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.					
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ ахиулахын тулд бие дан суралцдаг.					
Эмнэлгийн бусад тасгийн эмч нартай хамтран ажилладаг.					
Эмнэлгийн доторх туслаж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.					

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: “Тэр найдваргүй” гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт нь “Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубын 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй”.

Өөрөөсөө асуу: “Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?”

Хавсралт 3

Эмнэл зүйн MINI-CEX үнэлгээний хуудас

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр _____ Үнэлэгчийн нэр: _____

Үнэлгээ хийсэн газар: Тасаг Амбулатори Боолтын өрөө Хагалгааны өрөө

Өвчтөний нас _____ Хүйс Эр Эм

Үнэлэх шинжүүд буюу өвчтөний зовиур: В-шинж тэмдэг Цус алдалт, хуралт Өвдөх
 Хаван Толгой хүзүүнд гарсан үүсвэр Саа саажил Амьсгал бачуурал (дуу сөөх)
 Амны хөндийн салстын өөрчлөлт Арьсны шарх, мэнгэ Сорви, наалдац (эмчилгээний дараах өөрчлөлт) Хамар, амны хөндий, залгиурын хавдрын шинж (шүд сулрах, залгих, ярих өөрчлөгдөх, хамар байнга битүүрэх)

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө			Бусад санал
Сургалтын тухайн үед суралцагч эмчийн түвшинг ажигласнаа үнэлнэ үү. Бодит үзлэг хийх шардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү. <input type="checkbox"/>				Сайжрахын тулд хийх үйлдэл
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	
Өвчний түүх нээх				
Бодит үзлэг				
Оношлогоо, эмчилгээний менежмент				
Харилцааны ур чадвар				
Эмнэл зүйн ерөнхий чадвар				

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

Хангалттай гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд	
Өвчний түүх авах, нээх	<ul style="list-style-type: none">Ялган оношлогоо хийхүйц дэлгэрэнгүй авахӨвчтөний хэрэгцээг илрүүлж хариу өгдөгӨвчтөний дохио зангааг ойлгож тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none">Ялган оношлогоо хийхүйц дэс дараатай бодит үзлэг хийдэгҮзлэгийн үед өвчтөнд таатай байх орчныг бүрдүүлдэг
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none">Зөв онош тавьдаг.Шаардлагатай шинжилгээг зөв төлөвлөж эмчилгээнд ашигладаг.Тохирсон эмчилгээг эхлүүлдэгШаардлагатай бол тохирсон тасагт шилжүүлдэг
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none">Өвчтөн, түүний ар гэрийг сайн сондог.Өвчтөн, түүний ар гэр, асран хамгаалагчийн зовнилыг хуваалцан ойлгож хүндэтгэлтэй ханддаг.Өвчтөн, түүний ар гэр, асран хамгаалагчтай эелдэг, энгийн үгээр харьцдаг
Эмнэл зүйн	<ul style="list-style-type: none">Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг.

ерөнхий чадвар

- Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрнө.

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭ

Он сар өдөр / /

Суралцагч эмчийн нэр_____ Үнэлэгчийн нэр: _____

Газар: Тасаг Амбулатори Боолтын өрөө Хагалгааны өрөө

Гардан үйлдэл (доогуур нь зур): Үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх, эдийн шинжилгээ авах, хортой болон хоргүй хавдрын мэс засал. Шарх цэгцлэлт, оёдол тавих, боолт эмчилгээ хийх.

Оролцсон хагалгаа: Хэсгийн мэдээ алдуулалттай болон ерөнхий мэдээ алдуулалттай мэс засалд оролцох.

Одоог хүртэл хийсэн гардан үйлдлийн тоо _____

Үнэлгээ	Хангалт-гүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй /үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдварүйжүүлэх үйлдлийг хийдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлээ ойлгож тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг.				
Шаардлагатай баримт бичгийг гүйцэт хөтөлдөг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж: Сайн тал

Сайжруулах тал

Бусад санал:

Үнэлэгч: _____

Суралцагч: _____